

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 03 дугаар сарын 28

Дугаар 31

Улаанбаатар хот

Бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зургадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Баянзүрх дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн А/03 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн дунд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хамтын ажиллагааг уялдуулан зохион байгуулж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА

А.БАЯР

Баянзүрх дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03
дугаар сарын 28-ны өдрийн зургадугаар
хуралдааны 31 дүгээр тогтоолын
хавсралт

Баянзүрх дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга:	Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын дарга
Нарийн бичгийн дарга:	Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга
Гишүүд:	Дүүргийн Засаг даргын зөвлөх Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан Засаг даргын орлогч Засаг даргын Тамгын газрын дарга Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Дүүргийн прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх Дүүргийн Цагдаагийн газрын дарга Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга Дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга Дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга Дүүргийн Боловсролын хэлтсийн дарга Дүүргийн Газар зохион байгуулалтын I, II алба Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны Баянзүрх дүүргийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс “Гэр бүл, хүүхэд, залуучуудад эрх зүйн үйлчилгээ үзүүлэх Цагаан шонхор төв” Төрийн бус байгууллага